



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/200

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5.7, 3.6.7, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжийн мод бэлтгэл, хортон шавж устгалын гүйцэтгэлд хяналт тавих ажлын шатахууны зардалд 4,499,952 (дөрвөн сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуун тавин хоёр) төгрөг, хүнсний зардалд 1,548,000 (нэг сая таван зуун дөчин найман мянга) төгрөг, нийт 6,047,952 (зургаан сая дөчин долоон мянга есөн зуун тавин хоёр) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 6,047,952 (Зургаан сая дөчин долоон мянга есөн зуун тавин хоёр) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг сумын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

